Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, Засаг дарга Т.Лхагвасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил Манхан аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн ОНХС-гийн хөрөнгийг батлуулж зарцуулахдаа Сангийн сайдын холбогдох журмуудыг зөрчдөг байдлыг таслан зогсоох, орлогын бүртгэл, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 19-нээс 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга нар гүйцэтгэв.

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 1/106 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Манхан сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Манхан сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Манхан сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлог/-ыг сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлогын 4986341.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 49863.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 84484.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 105132.5 мянган төгрөг болж 20648.4 мянган төгрөгөөр буюу 24.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1: Мөнгөн хөрөнгө

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНХС	274.9	27831.9	27557.0	10024.4
СХС	47730.4	7893.9	-39836.5	-83.5
Төрийн сан	36478.8	69406.7	32927.9	90.3
<b>Дүн</b>	<b>84484.1</b>	<b>105132.5</b>	<b>20648.4</b>	<b>24.4</b>

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 105132.5 мянган төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 221562.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 268880.8 мянган төгрөг болж 47318.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	740.9	202.3	-538.6
Байгууллагаас авах авлага	7628.4	9072.9	1444.5
Хувь хүмүүсээс авах авлага	30002.0	29325.1	-676.9
Зээлийн хүүгийн авлага	2725.1	3406.7	681.6
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	180466.0	223002	42536

татаас санхүүжилтийн авлага		3871.8	3871.8
<b>Дүн</b>	<b>221562.4</b>	<b>268880.8</b>	<b>47318.4</b>

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 252327.1 мянган төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 180466.0 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант 97500.0 мянган төгрөгийн зээл олгож, 58446.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 223002.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онуудад олгосон 35 зээлдэгчийн 142685.8 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2016 онуудад олгосон 19 иргэнтэй холбогдох 83722.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 18 иргэнтэй холбогдох авлагыг 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр шүүх, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй хашааны авлагын эхний үлдэгдэл 28725.1 мянган төгрөгөөс тайлант онд 4100.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж 4700.0 мянган төгрөгийг хашааны зээлийг нэмж олгон 29325.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ОНХС-гийн авлагыг тайлант онд 600.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн зөрчил илэрлээ.

### 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 242046.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 284120.3 мянган төгрөг болж 42074.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3: Бараа материалын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	27455.4	28811.5	1356.1
Эм боох материал	18654.2	31942.2	13288.0
Бичиг хэргийн материал	638.4	701.1	62.7
Аж ахуйн материал	46368.4	49448.7	3080.3
Сэлбэг хэрэгсэл	813	703	-110.0
Түлш, шатах тослох материал	3749.2	3718	-31.2
Барилгын засварын материал	258	258	0.0
Хүнсний материал	22514.2	25850.9	3336.7
Бусад хангамжийн материал	121283.3	142374.9	21091.6
Мал амьтад	312	312.0	0.0
<b>Дүн</b>	<b>242046.1</b>	<b>284120.3</b>	<b>42074.2</b>

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЕБС –ийн бараа материалын дансны үлдэгдэл 139965.27 мянган төгрөг болж 12828.91 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эм, ариутгалын бодис болон ажилчдын нормын хувцас, хүнс нөөцөлж авсан байгаа нь нөлөөлж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн бараа материалын дансны үлдэгдэл 53358.4 мянган төгрөг болж 28245.7 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд бусад хангамжийн материал 16919.7, аж ахуйн материал 2704.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засаг даргын Тамгын газрын бараа материалын дансны үлдэгдэл 28245.7 мянган төгрөг болж 2313.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 2337.1 мянган төгрөгийн аж ахуйн материал акталсантай холбоотой байна.

Эрүүл мэндийн төвийн бараа материалын дансны үлдэгдэл 53585.6 мянган төгрөг болж 12952.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой эм болон бусад хангамжийн материал нөөцөлсөнтэй холбоотой байна.

Соёлын төвийн бараа материал дансны үлдэгдэл 3330.9 мянган төгрөг болж өмнөх оноос 707.1 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар буурсан байна. Тайлант онд 5325.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 6032.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

- ЕБС нь 2019 оны эцсийн үлдээдлийг бусдад зарж борлуулахдаа 3591.5 мянган төгрөгийн махны үлдээдлийг цаашид ашиглах боломжгүй гэж акталсан байна.
- Хүүхдийн цэцэрлэг нь цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын нээлттэй холбоотойгоор 1658.2 мянган төгрөгийн хүүхдийн хүнсний материалыг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ЕБС нь 2019 оны сүүлээр нөөцөлсөн махыг бусдад зарж борлуулахдаа 3190.6 мянган төгрөгийн махыг хэнд зарсан нь тодорхой бус мөнгөн хөрөнгийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 9279705.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11074275.8 мянган төгрөг болж 1794570.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Барилга байгууламж, орон сууц	6869730	8,443,362.1	1,573,632.1	
Тээврийн хэрэгсэл	271081.2	276,501.2	5,420.0	
Машин тоног төхөөрөмж	608380.8	781,304.4	172,923.6	
Тавилга эд хогшил	372721.1	406,124.2	33,403.1	
Түүх соёлын дурсгалт зүйл	25710.7	25,710.7	-	
Зам гүүрний байгууламж	836,286.9	836,286.9	-	
Номын фонд	104849.3	113,981.1	9,131.8	
Бусад үндсэн хөрөнгө	6850.0	6,850.0	-	
Программ хангамж	4425.0	4,485.0	60.0	
Бусад биет бус хөрөнгө	179670.2	179,670.2	-	
<b>Дүн</b>	<b>9,279,705.20</b>	<b>11,074,275.8</b>	<b>1,794,570.6</b>	

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 11399.7 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 36254.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 1747666.6 мянган төгрөгөөр нэмэгдэж акталсан 750.0 мянган төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 10837.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1452.8 мянган төгрөг болж 1452.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5: Өр төлбөрийн үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	1191.5	682.8	-508.7	-42.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	50	0	-50	-100.0
Байгууллагад төлөх өглөг	8751.9	7.9	-8744	-99.9
Хувь хүмүүст төлөх өглөг	844.5	833.9	-10.6	-1.3
<b>Нийт дүн</b>	<b>10837.9</b>	<b>1524.6</b>	<b>-9313.3</b>	<b>-85.9</b>

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1452.8 мянган төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7678322.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 9118142.3 мянган төгрөг болж 1439819.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6: Засгийн газрын хувь оролцоо

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,452,520.9	3,452,520.9	0	0
Хуримтлагдсан үр дүн	2,029,709.6	3,469,529.4	1439819.8	70.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,196,092.0	2,196,092.0	0	0
<b>Дүн</b>	<b>7,678,322.5</b>	<b>9,118,142.3</b>	1439819.8	18.8

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 3469529.4 мянган төгрөг болж 1439819.8 төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн данснаас шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

#### Нийт үр дүнгийн тайлангийн орлого бичих

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 4985827.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1259270.4 мянган төгрөгөөр буюу 33.8 хувиар өссөн байна.

Нэмэгдсэн 125270.4 мянган төгрөгийн орлогоос материаллаг өөрчлөлт орсон татварын орлого 17745.1 мянган төгрөг буюу 28.3 хувиар, торгуулийн орлого 27466.2 мянган төгрөг буюу 100.4 хувиар, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1557844.8 мянган төгрөг буюу 670.5 хувиар, бусад орлого 9818.8 мянган төгрөг буюу 5418.7 хувиар, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 304931.1 мянган төгрөг уюу 19 хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 97028.7 мянган төгрөг буюу 66.9 хувиар, нийгмийн даатгалын сангаас санхүүжих орлого 1967.3 мянган төгрөг буюу 4.8 хувиар нэмэгдэж орон нутгийн төсвөөс санхүүжигдэх орлого 70712.7 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар, үндсэн үйл ажиллагааны орлого 1245.0 мянган төгрөг буюу 15.4 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 1159.4 мянган төгрөг буюу 19.6 хувиар тус тус буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- СХС-гийн орлогыг 1195.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

-Орон нутгийн татварын орлогын биелэлтэд санхүүгийн албаны дарга хяналт тавиагүй хэдэн төгрөгийн орлого орохоос хэдэн төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн талаарх мэдээллийг аудитад гаргаж өгөөгүй.

### 3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3546121.4 мянган төгрөг болж өмнөх оноос 344765.9 мянган төгрөг буюу 8.9 хувиар буурсан байна.

Буурсан 344765.9 мянган төгрөгийн зардлаас материаллаг өөрчлөлт гарсан дараах зардлууд байна. Үүнд: Цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 316752.8 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 29227.9 мянган төгрөгөөр буюу 9 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 47388.1 мянган төгрөг буюу 8.9 хувиар нэмэгдэж хангамж, бараа материалын зардал 56609.9 мянган төгрөг буюу 27.6 хувиар нормативд зардал 39561.8 мянган төгрөг буюу 29.2 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 2187.6 мянган төгрөг буюу 32.4 хувиар, томилолтын зардал 5683.8 мянган төгрөг буюу 54.3 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 11642.7 мянган төгрөгөөр буюу 25.9 хувиар, урсгал шилжүүлэг 622448.9 мянган төгрөгөөр буюу 75.5 хувиар буурсан байна. Зардал буурах болсон шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

Зардлын данстай холбоотой 100662.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтыг зөрчин ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй байхад ИТХ-аар оруулан батлуулсан. 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж 84483.1 мянган төгрөгийг санхүүжүүлжээ. .
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Ахмадаа ачилъя” хөтөлбөрийн хүрээнд ахмад настнуудад 1000.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон.
- Баянгол багийн кемп засварын ажлыг иргэн Я.Бямбабаяраар хийлгэхээр 2020 оны 5 сарын 27-ны өдөр 3500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл хүлээн аваагүй, тухайн иргэн нь ямар ч ажил хийгээгүй байна.
- “ИТХ-ын үйл ажиллагаанд” хөтөлбөрт иргэдийн санал аваагүй 5640.2 мянган төгрөгийг батлуулан гүйцэтгэлээр 5640.2 мянган төгрөгийг санхүүжүүлсэн.
- “Нийтийн биеийн тамир” хөтөлбөрт иргэдийн санал аваагүй 7000.0 мянган төгрөгийг батлуулан 1244.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг холбогдох хууль, журмыг зөрчин санхүүжүүлжээ.
- Иргэдийн санал аваагүй “Ковш засвар” гэсэн арга хэмжээг батлуулан ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд 3000.0 сая төгрөг батлуулан зарцуулжээ
- СХС-гийн зардлыг 1795.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Манхан сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 13/02 дугаар тогтоолд Манхан сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 197702.6 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 215796.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт дугаар 7. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	197,702.6	215,796.8	18,094.2
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>197,702.6</b>	<b>215,796.8</b>	<b>18,094.2</b>
<b>Татварын орлого</b>	<b>43,467.4</b>	<b>80,390.8</b>	<b>36,923.4</b>
<b>Орлогын албан татвар</b>	<b>13,575.0</b>	<b>50,630.4</b>	<b>37,055.4</b>
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>13,575.0</b>	<b>50,630.4</b>	<b>37,055.4</b>
Үйл ажиллагааны орлого	1,500.0	19,531.9	18,031.9
Шууд бус орлого	12,075.0	31,098.5	19,023.5
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>23,678.4</b>	<b>24,329.4</b>	<b>651.0</b>
Бууны албан татвар	2,798.4	3,000.0	201.6
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	20,880.0	21,329.4	449.4
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>6,214.0</b>	<b>5,431.0</b>	<b>(783.0)</b>
<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>4,086.0</b>	<b>3,080.3</b>	<b>(1,005.7)</b>
Улсын тэмдэгтийн хураамж	2,450.0	1,305.3	(1,144.7)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	500.0	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,136.0	1,275.0	139.0
<b>Газрын төлбөр</b>	-	<b>687.7</b>	<b>687.7</b>
Газрын төлбөр	-	687.7	687.7
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>2,128.0</b>	<b>1,663.0</b>	<b>(465.0)</b>
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	-	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	428.0	433.0	5.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,700.0	1,230.0	(470.0)
<b>Татварын бус орлого</b>	<b>154,235.2</b>	<b>135,406.0</b>	<b>(18,829.2)</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>154,235.2</b>	<b>135,406.0</b>	<b>(18,829.2)</b>
Торгуулийн орлого	38,625.0	54,804.5	16,179.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого	105,610.2	70,601.5	(35,008.7)
Бусад орлого	10,000.0	10,000.0	-

Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 18094.2 мянган төгрөг буюу 18094.2 мянган төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 37055.4, хөрөнгийн албан татварын орлого 651.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлж бусад татвар, төлбөр хураамж 783.0, байгалийн нөөц ашигласны төлбөр 465.0, татварын бус орлого 18829.2 мянган төгрөгөөр тасалжээ. Татварын бус орлого тасрах үндсэн шалтгаан нь СХС-гийн орлогыг 38384.4 мянган төгрөгөөр тасалснаас шалтгаалжээ.

#### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3153486.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3153486.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг сая 3153486.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 3153486.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2923899.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 132756.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлийн зардалд 96830.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1905522.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 1099712.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 42641.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 105335.4 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 274.8 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хүснэгт дугаар 8. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
1	ЗДТГ	448,661.9	605.0	449,266.9	427,581.9	605.0	428,186.9	(21,080.0)	
2	ИТХ	58,336.1	-	58,336.1	58,146.1	-	58,146.1	190.0	
3	Сум хөгжүүлэх сан		96,830.4	96,830.4		58,446.0	58,446.0	(38,384.4)	СХС-гийн эргэн төлөлтийг дутуу төлүүлсэнтэй холбоотой
4	ОНХС	107,940.2	-	107,940.2	107,940.2	-	107,940.2	-	
	<b>ОНБ-дын дүн</b>	<b>614,938.2</b>	<b>97,435.4</b>	<b>712,373.6</b>	<b>593,668.2</b>	<b>59,051.0</b>	<b>652,719.2</b>	<b>(59,274.4)</b>	
5	ЕБСургууль	1,352,932.2	400.0	1,353,332.2	1,275,007.2	-	1,352,932.2	400.0	өөрийн орлого биелээгүй
6	Хүүхдийн цэцэрлэг	373,994.1	-	373,994.1	319,564.0	-	373,994.1	-	
7	Эрүүл мэндийн төв	445,993.5	-	445,993.5	445,993.5		445,993.5	-	
8	Соёлын төв	128,979.3	2,500.0	131,479.3	128,979.3	1,255.0	130,234.3	1,245.0	өөрийн орлого биелээгүй
9	Спорт цогцолбор	131,039.0	5,000.0	136,039.0	131,039.0	5,000.0	136,039.0		
	<b>ТЗШ дүн</b>	<b>2,432,938.1</b>	<b>7,900.0</b>	<b>2,440,838.1</b>	<b>2,169,544.0</b>	<b>1,255.0</b>	<b>2,303,154.1</b>	<b>1,645.0</b>	
	<b>Нийт дүн</b>	<b>3,047,876.3</b>	<b>105,335.4</b>	<b>3,153,211.7</b>	<b>2,763,212.2</b>	<b>60,306.0</b>	<b>2,955,873.3</b>	<b>(57,629.4)</b>	

Эх үүсвэр: Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн үйл ажиллагааны орлого 60306.0 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 37984.4 сая төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого, сургууль өөрийн орлогын төлөвлөгөөг биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 29 төсөл, арга хэмжээнд 132756.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 107713.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож үлдэгдэл 25039.5 мянган төгрөг нь ОНХС-гийн дансанд үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2957335.7 мянган төгрөг нь 97,7 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, сургуулийн өөрийн орлого тасарсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 126111.8 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/- 67209.3, дээд шатны төсвийн захирагчаас 23957.9 үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 6184.1 мянган төгрөг нийт 97351.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт №.9. Нэмэлт данс			/мянган	
			төгрөг/	
	Бусад орлого	Нийт		
1	ЗДТГ	72097,5	72097,5	ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллогын зардал
3	ЕБСургууль	1076,0	1076,0	төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс
5	ЭМТ	18811,6	18811,6	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс
<b>Нийт дүн</b>		<b>97351,3</b>	<b>97351,3</b>	

Үүнээс үндсэн цалинд 10355.0 мянга, хангамж бараа материалын зардалд 603.9 мянга, норматив зардалд 2852.8 мянга, урсгал засварт 5000.0 мянга, Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 3424.0 мянга, Бараа үйлчилгээний бусад зардал 70149.5 мянга, урсгал шилжүүлэгт 4966.2 мянга нийт 97351.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 13152.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 4910.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 26266.1 мянган төгрөгийн 16 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 66% хэрэгжсэн байна.

Хүснэгт 10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	13152.6	0	3147.1	1	10005.5	30%
Албан шаардлага	2	4910.4	2	4910.4	0	0	100%
Зөвлөмж	13	26266.1	10	26266.1	3	0	50%
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>44329.1</b>	<b>11</b>	<b>19623.6</b>	<b>5</b>	<b>24705.5</b>	<b>66%</b>

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн ТТЗ-ийн санхүүгийн тайлангаар өгөгдсөн 13152.6 мянган төгрөгийн төлбөрийн актаас 3147.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг биелүүлэн үлдэгдэл 10005.5 мянган төгрөгийн актыг биелүүлээгүй байна. Мөн ТТЗ-д өгөгдсөн 4 зөвлөмжөөс жолоочийн тооцоо бодож замын хуудсыг бичүүлэн ажиллах 1 зөвлөмж хэрэгжиж бусад 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №11. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

Байгууллагын ангилал, нэр	Дүгнэлт				
	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Татгалзсан	Тайлбар
Төсвийн шууд захирагч	ЗДТГ	1			
	ИТХ				түүвэрт хамрагдсан
	Сургууль	1			
	Цэцэрлэг		1		
	ЭМТ	1			
	Соёлын төв	1			
	спорт цогцолбор	1			
ОНТС	СХС				түүвэрт хамрагдсан
	ОНХС				түүвэрт хамрагдсан
ТТЗ	Сумын нэгтгэл				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1</b>			

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-5, “Хязгаарлалттай” 1 нийт 6 дүгнэлт гаргасан байна.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:**

Аудитаар нийт 112462.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3590.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3500.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 20889.7 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 84483.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 600.0 мянган төгрөгөөр хашааны авлагыг дутуу нэгтгэсэн
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийн орлого 1195.0 мянган төгрөгөөр илүү, 1795.0 мянган төгрөгөөр зардлыг дутуу нэгтгэсэн;

### **Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Баянгол багын кемпийн худаг засварын ажилд 3500.0 мянган төгрөгийг олгоод ажлаа хийгээгүй байхад авлагаар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, “Оршин

байх”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт бичих

Орон нутгийн хөгжлийн сангийн холбогдох журмыг зөрчин ИТХ-ийн төлөөлөгчдийг дэмжих үйл ажиллагаанд нь 5640.2 мянган төгрөг, Ахмадаа ачилъя хөтөлбөрийн хүрээнд ахмад настнуудад түлшний хөнгөлөлт олгосонтой холбоотой 1000.0 мянган төгрөг, нийтийн биеийн тамир хөтөлбөрийн хүрээнд 1244.0 мянган төгрөг, ЗДТГ-ын ковш засварт 3000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Өмнөх Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 10005.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3 зөвлөмжийг биелүүлээгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй байгаа нь “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх

Төвлөрүүлсэн захирагчид 84483.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

**Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил**

Манхан сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 40087.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 8411.6 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 31675.5 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 3190.6 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 1658.2 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд албан шаардлага, 26826.7 мянган төгрөгийн 11 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт № 12. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/*

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЗДТГ	3	16,311.1	1.0	8,411.6	2	7,899.5
2	ИТХ	-	-				
3	Төсвийн шууд захирагч Сургууль	2	3,502.6			2	3,502.6
4	Цэцэрлэг	3	4,562.4			3	4,562.4
5	ЭМТ	2				2	
6	Соёлын төв	2	15,711.0	-	-	2.0	15,711.0

7	Спорт цогцолбор	2					2
8	ОНТС	СХС	-	-			
9		ОНХС	-	-			
	ТТЗ	Сумын нэгтгэл	-	-			
	<b>Дүн</b>		<b>14</b>	<b>40,087.1</b>	<b>1.0</b>	<b>8,411.6</b>	<b>13</b>
							<b>31,675.5</b>

№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо
1	ЗДТГ	2	7,899.5	-	-	-	-	2	7,899.5	
2	ИТХ	0	-	-	-	-	-	-	-	
3	Сургууль	2	3,502.6	1	3,190.6			1	312.0	
4	Төсвийн шууд захирагч	Цэцэрлэг	3	4,562.4	-	-	1	1,658.2	2	2,904.2
5		ЭМТ	2	-					2	
6		Соёлын төв	2	15,711.0	-	-	-	-	2	15,711.0
7		Спорт цогцолбор	2						2	
7	ОНТС	СХС	0	-	-	-	-	-	-	
8		ОНХС	0	-	-	-	-	-	-	
	<b>Дүн</b>		<b>13</b>	<b>31,675.50</b>	<b>1</b>	<b>3190.6</b>	<b>1</b>	<b>1658.2</b>	<b>11</b>	<b>26,826.7</b>

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, чанартай холбоотой асуудлыг цаг хугацааны хувьд газар дээр нь очиж үзэж амжаагүй болно.

#### 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сумын ОНХС-гийн хөрөнгийг зарцуулахдаа иргэдийн санал аваагүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг батлуулсан, техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөвгүй нийт ажлыг ИТХ-аар батлуулж санхүүжүүлжээ.
- 1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх”, 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр,

төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтуудыг зөрчин иргэдийн санал аваагүй, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөө, техник эдийн засгийн үндэслэлгүй байхад арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж зарцуулдаг байдлыг таслан зогсоох

#### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### 2.1 . Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

**2.1.1. Илрүүлэлт:** Тайлант онд тус байгууллага нь татварын болон татварын бус орлогыг дансанд орсон мөнгөн дүнгээр нь тайлагнаж санхүүгийн албаны дарга нь өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилтыг хэрэгжүүлээгүй байна.

**2.1.2. Эрсдэл:** Орлогын төлөвлөгөө тасрах, татварын орлого төлөгдөхгүй байх, татвараас зайлсхийх

**2.1.3 Өгсөн зөвлөмж:** Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 42 тоот тогтоолын 2-р хавсралтын 1 дүгээр зорилтын 6-д “Орлогын тогтвортой бааз суурьтай болох судалгаа, мэдээллийн сан бий болгох”, 2-р зорилтын 8-д “Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтантай тооцоо нийлж...”, 3-р зорилтын хүрээнд “сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдтэй тооцоо нийл орлогыг бүрэн оруулахад анхаарч ажиллах.

**2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

### 3.1 . Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

**3.1.1. Илрүүлэлт:** Сумын хэмжээнд худалдан авсан бараа бүтээгдэхүүн худалдан авахад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

**3.1.2. Эрсдэл:** Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

**3.1.3 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулахад анхаарч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, Төрийн сангийн төлөөлөгч нарыг удирдлагаар ханган ажиллах

**3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Манхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
--------	--------------	--	--------------

2020

ХОА-2021/07/СТА-ТТЗ

Шалгагдсан  
байгууллагын нэр:

Манхан сумын Засаг дарга

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ОНХС-гаас мөнгөн хөрөнгө аваад одоо болтол ажлаа хийгээгүй	3500.0	Төлбөрийн акт бичих	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Т.Лхагвасүрэн Б.Баярхишиг
2	ОНХС-гаас Төсвийн тухай хуулийг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн.	10884.2	Албан шаардлага		
3	ТТЗ-ийн өмнөх СТА-аар өгөгдсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй	10005.5	Хариуцлага тооцуулах албан шаардлага		
4	Залруулсан алдаа	3590.0	Залруулах		
5	ОНХС-гийн журмыг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн	84483.1	Зөвлөмж өгөх		
6	Санхүүгийн албаны дарга албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй	0	Зөвлөмж өгөх		
7	Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	0	Зөвлөмж өгөх		
	<b>Дүн</b>	112462.8			

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**